



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 04

Мандалговь

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннаймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гурвансайхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 500,000 (таван зуун мянга) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй барааны складыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гурвансайхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Т.Өлзий-Орших)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг Сум байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлого 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
04 дугаар тогтоолын хавсралт

Гурвансайхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн актлах хөрөнгийн мэдээлэл



№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа / жилээр /	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжих нэгж	биет хэмжээ					
1	Барааны склад	Барааны агуулах	м.кв	4*3	2008.06.30	15	500,000.00	500,000.00	-
Нийт дүн							500,000.00 /таван зуун мянга/ төгрөг	500,000.00 /таван зуун мянга/ төгрөг	